



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 7 сарын 21 өдөр

Дугаар 84

Эрдэнэт

Ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн сан, ажилтнуудын хариуцах ажлын чиглэл шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалтыг үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албыг 14 орон тоотой байхаар тогтоосугай.

2. Аймгийн ИТХ-ын Ажлын албаны бүтцийг нэгдүгээр хавсралтын ёсоор, Ажлын албаны ажилтнуудын хариуцах ажлын чиглэлийг хоёрдугаар хавсралтын ёсоор, Ажлын албаны ажилтнуудын цалингийн санг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 12, 124 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолыг 2016 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



П. ПУРЭВЛХАГВА